



## **“ГАДААД БАГШ, ЗОЧИН ПРОФЕССОР, МЭРГЭЖИЛТНИЙГ УРЬЖ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ”**

### **I. Нийтлэг үндэслэл**

1.1 Гадаадын их, дээд сургууль, эрдэм шинжилгээний болон бусад байгууллагаас ШУТИС-д гадаад багш, зочин профессор, мэргэжилтэн (цаашид гадаадын иргэн гэх) урьж ажиллуулахад энэ журмыг баримтална.

1.2 Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, Боловсролын болон Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан болон Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль (ШУТИС)-ийн дүрэм, журамд нийцүүлэн энэхүү журмыг мөрдлөг болгоно.

### **II. Гадаадын иргэнийгурьж ажиллуулах**

2.1 ШУТИС-д урилгаар ажиллах гадаадын иргэн нь тухайн мэргэжлээрээ их дээд сургууль төгссөн, магистр, түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой, ажлын зохих дадлага, туршлагатай байна.

2.2 ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, институт, нэгжийн удирдлага, холбогдох салбар, тэнхимийн саналыг үндэслэн гадаад багш, зочин профессор, мэргэжилтэн урьж ажиллуулах хүсэлтийг Гадаад харилцаа, хамтын ажиллагаа(ГХХА)-ны албанад бичгээр гаргана.

2.3 Гадаадын иргэнийг урьж ажиллуулах хүсэлт, шаардагдах бусад бичиг баримт, материалыг тухайн гадаадын иргэн Монгол улсад ирэхээс хоёр сарын өмнө ГХХА-ны албанад ирүүлнэ. Гадаад хэл дээрх бичиг баримтыг Монгол, Англи хэл дээр боловсруулж, баталгаажуулсан байна. Үүнд:

- Гадаадын иргэний дэлгэрэнгүй анкет /Монгол, Англи хэл дээр /
- Хөдөлмөрийн гэрээ (Монгол, Англи хэл дээр гэрээг байгуулж, баталгаажуулсан байх)
- Мэргэжлийн үнэмлэх, диплом, сертификатын баталгаажуулсан хуулбар (Монгол хэл дээр хөрвүүлсэн байх)
- Паспортын хуулбар
- Эрүүл мэндийн тодорхойлолт /Монгол хэл дээр хөрвүүлсэн байх/
- Байгууллагын албан бичиг, тодорхойлолт

2.4 Гадаадын иргэн нь ямар нэгэн нийгмийн халдварт өвчингүй, эрүүл, хөдөлмөр эрхлэх чадвартай байна.

2.5 Гадаадын иргэнийг урьж ажиллуулахтай холбоотой хууль, тогтоомж, бүрдүүлэх материалын талаар ГХХА-ны албанаас заавар, зөвлөлгөө авч ажиллана.



ШУТИС-ийн ректорын 2015 оны 3 сарын  
18.. өдрийн тоот тушаалын хавсралт

2.6 Гадаадын иргэний бүрдүүлсэн материал, бүрэлдэхүүн сургууль, институт, нэгжийн хүсэлтийг үндэслэн ГХХА-ны алба гадаадын иргэнд виз, Монгол улсад оршин суух болон хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох асуудлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад хандан шийдвэрлүүлж, хариуг хүсэлт гаргасан нэгж, гадаадын иргэнд мэдэгдэнэ.

### III. Гадаадын иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, сунгах, цуцлах

3.1 ШУТИС-д урилгаар ажиллах гадаад багш, зочин профессорыг бүрэлдэхүүн сургууль, институт, холбогдох салбар, тэнхимиийн санал болон эрдмийн зэрэг цол, ажилласан жил, дадлага туршлагыг харгалзан түүнтэй дүйцэх багшийн албан тушаалд ажиллуулж болно.

3.2 Гадаадын иргэнийг урьж ажиллуулах бүрэлдэхүүн сургууль, институт, нэгжийн удирдлага гадаадын иргэнтэй ажлын төлөвлөгөө гарган, хөдөлмөрийн гэрээг Монгол, Англи хэл дээр байгуулан, Ректороор батлуулна.

3.3 Гадаадын иргэний хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл нь нэг жил хүртэл хугацаатай байх бөгөөд зөвшөөрлийн хугацааг байгууллагын хүсэлт, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний үр дүн, цаашид ажиллуулах болсон шалтгааныг үндэслэн сунгаж болно.

3.4 Гадаадын иргэнтэй байгуулах хөдөлмөрийн гэрээнд Монгол улсын хөдөлмөрийн хуулийн холбогдох зүйл заалтуудыг тусгахаас гадна цалин хөлс, оршин суух байр, даатгалын төлбөр, бусад зардлыг аль тал нь хариуцах болон эх үүсвэрийн талаар тодорхой тусгана.


3.5 Гадаадын иргэнтэй байгуулах хөдөлмөрийн гэрээ нэг жил хүртэл хугацаатай байх бөгөөд түүнийг үргэлжлүүлэн сунгах буюу хөдөлмөрийн гэрээний тодорхой зүйл, заалтыг зөрчсөн болон гэрээний хэрэгжилт зэргийг үндэслэн цуцалж болно.

### IV. Гадаадын иргэнийг урьж ажиллуулах бүрэлдэхүүн сургууль, институт, нэгжийн үүрэг

4.1. Гадаадын иргэнийг Монгол улсад нэвтэрснээс 7 хоногийн дотор Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газарт шаардагдах бичиг баримтыг бүрдүүлэн бүртгүүлж, 21 хоногийн дотор оршин суух зөвшөөрлийг авна. Хэрэв энэ хугацаанд зохих журмын дагуу бүртгүүлээгүй, оршин суух зөвшөөрлөө аваагүй тохиолдолд хуулийн дагуу холбогдох хариуцлагыг ажиллуулахаар урьсан бүрэлдэхүүн сургууль, институт, нэгжийн удирдлага бүрэн хариуцна.

4.2. Гадаадын иргэний Монгол улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (ХЭҮТ)-өөс холбогдох бүрэлдэхүүн сургууль, институт, нэгжийн удирдлага зохих журмын дагуу авна.

4.3. Гадаадын иргэдийн бүртгэл, оршин суух болон хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хураамж, төлбөрийг тухайн урьж ажиллуулах бүрэлдэхүүн сургууль, институт хариуцна.



ШУТИС-ийн ректорын 2015 оны 3 сарын  
18... өдрийн 68 тоот тушаалын хавсралт

4.4 Монгол улсад зорчих, оршин суух, хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хууль тогтоомжууд болон ШУТИС-ийн дүрэм, журмыг гадаадын иргэнд танилцуулах үүрэг хүлээнэ.

4.5 Монгол Улсад оршин суух болон хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан, цаашид үргэлжлүүлэн сунгахгүй тохиолдолд бүртгэлээс хасуулах, буцаах үүрэг хүлээнэ.

4.6 Гадаадын иргэнийг их сургуулийн үйл ажиллагаатай танилцуулж, оршин суух орон байр олоход нь туслах болон хөдөлмөр эрхлэх аюулгүй орчин, нөхцлийг бүрдүүлж ажиллана.

4.7 Гадаад багш, мэргэжилтэн, зочид төлөөлөгчдөд үйлчлэх, угтах, үдэхэд техникийн хувьд бүрэн бүтэн байдлыг хангасан тээврийн хэрэгслээр, эрх бүхий жолооч үйлчилж, гадаадын иргэний аюулгүй байдлыг хангаж ажиллана.

## V. Бусад

5.1 Гадаадын иргэн нь холбогдох Монгол Улсын хууль, тогтоомж болон ШУТИС-ийн дүрэм, журамтай танилцаж, дагаж мөрдөнө.

5.2 Сургалт, судалгааны чиглэлээр уригдан ажиллах гадаадын иргэн их сургуулийн үйл ажиллагаатай харшлах ямар нэгэн үзэл суртал, шашны суртал ухуулга явуулахгүй байх үүрэг хүлээнэ.